



# ТАРХИНЫ ҮХЭЛТЭЙ ДОНОР-ИЛРҮҮЛЭГ, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАСАН ТОХИОЛДЛЫН ҮР ДҮН

## Судалгааны баг

Б. АЛТАНТУЛГА	/ЭЭЭШСҮАЗА-ны мэргэжилтэн/
Г. БАТЦЭЦЭГ	/ЭЭЭШСҮАЗА-ны мэргэжилтэн/
Э. БАТЖАРГАЛ	/ЭЭЭШСҮАЗА-ны мэргэжилтэн/
П. МИДРИЙМАА	/ЭЭЭШСҮАЗА-ны мэргэжилтэн/
П. БАТЧУЛУУН	/ЭЭЭШСҮАЗА-ны дарга/

## ҮНДЭСЛЭЛ

Дэлхийд анх 1950 онд Данийн мэдээгүйжүүлгийн эмч Bjorn Ibsen зохиомол амьсгалын аппаратыг зохион бүтээснээр зүрх болон амьсгалыг тогтвортой барих боломж бүрдсэн. Үүнээс хойш амьсгал, зүрхний үйл ажиллагааг дэмжиж, бусад үйл ажиллагаа алдагдсан байдлыг ажиглан Францын мэдрэлийн эмч Mollaret 1959 онд анх тархины үхлийг оношилж “coma dépassé” буюу Кома гэсэн ойлголтыг гаргаж ирсэн бөгөөд 1968 онд Харвардын Анагаахын сургууль тархины үхлийн шалгуурыг тогтоон баталсан. Ингэснээр тархины үхлийг оношилж амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа эхлүүлэх боломж бүрдэн 1963 онд Бельгийн мэс засалч Dr. Guy Alexandre тархины үхэлтэй донороос анхны эрхтэн авах мэс засал хийсэн.

## ЗОРИЛТ

Монгол Улсад Донорын тухай хууль анх 2000 онд батлагдсан бөгөөд 2012 болон 2018 онд нэмэлт өөрчлөлтүүд хийгдэн шинэчлэгдсэн. 2018 оны нэмэлт өөрчлөлтөөр донорын зөвшөөрөл, тархины үхэлтэй донор, амьгүй донороос эд, эрхтэн авах, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба байгуулах шийдвэрийг гаргасан. 2021 оны байдлаар Монгол Улсад 4 донор эмнэлэг, 2 эрхтэн шилжүүлэн суулгах эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна.

Донор эмнэлгийн тархины үхэл тодорхойлох багтай эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба өдөр бүр холбогдож мэдээлэл авч тархины үхэлтэй донор гарсан тохиолдолд гэр бүлийн гишүүдтэй уулзаж донор болох санал тавьдаг. Шашин шүтлэг, үзэл бодол, энэ талаарх мэдээлэл ойлголт зэргээс шалтгаалж гэр бүл шийдвэрийг гаргадаг. Тархины үхэлтэй донорын илрүүлгийг нэмэгдүүлж, гэр бүлийн зөвшөөрлийн хувийг ихэсгэсэнээр эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тоо нэмэгдэж, олон хүний амь нас аврах, амьдралын чанарыг сайжруулах боломж бүрдэнэ.

## МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Судалгаанд 2018-2021 оны 10 дугаар сарын хугацаанд 4 донор эмнэлгийн тархины үхэл тодорхойлох багийн илрүүлсэн нийт 3052 тархины үхэл тодорхойлогдсон тохиолдлоос боломжит 43 донорын гэр бүлийн гишүүдтэй уулзсан уулзалтын үр дүнг сонгож авсан.

*Жич: Ковид 19 цар тахлын халдварын эрчтэй дэгдэлтийн улмаас түр хугацаагаар (2021 оны 6-9 дугаар сард) үйл ажиллагааг зогсоосон учир нь энэ хугацаанд реципиент халдвар авах, түүний улмаас нас баралт нэмэгдэх хандлагатай байсан болно.*

## ҮР ДҮН

Нийт 43 (n=43) тархины үхэлтэй донорын гэр бүлийн гишүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулсан бөгөөд 24 (55.8%) гэр бүл зөвшөөрч, 19 (44.2%) гэр бүл татгалзсан. Зөвшөөрсөн 24 тархины үхэлтэй донороос **21** нь бодит донор болж эд, эрхтэн авах мэс засал хийн **27** бөөр, **19** элэг, **51** шөрмөс шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийж 46 хүний амь нас аварч, 55 хүний амьдралын чанарыг сайжруулсан.

Гэр бүлийн татгалзсан зонхилох шалтгааныг авч үзвэл гэр бүлийн гишүүдийн мэдээлэл, ойлголт зөрүүтэйгээс 9 (47.3%), ламын зөвлөмж улмаас 8 (42.1%), бөөгийн шийдвэрээс хамаарсан 2 (10.6%) тохиолдол байлаа. Тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгуулсан 46 реципиентийн амьдрах чадвар (patient survival rate) 1 жил – 93.5%, 3 жил -87% байна. Нийт уулзалтанд оролцсон 34 гэр бүлийн гишүүдээс санхүүгийн дэмжлэгийн талаар асууж байсан болно.

## ДҮГНЭЛТ

Тархины үхэлтэй боломжит донорын гэр бүлийн гишүүдийг оролцуулан эрхтний донор болгох хүсэлт тавих уулзалтын үед тухайн гэр бүл донорын тухай, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээгээр дамжуулан хүний амь нас аврах, амьдралын чанарыг сайжруулах боломжтой талаарх зөв мэдээлэл, ойлголттой байх нь зөвшөөрөл өгөх магадлалд эерэгээр шууд нөлөөлж байгаа нь ажиглагдсан. Тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгуулсан реципиентийн амьдралын чанар нь эрс сайжирч амьдрах хугацаа уртассан байна.

## ТҮЛХҮҮР ҮГС

*амьгүй донор, донорын зөвшөөрөл, эрхтэн шилжүүлэн суулгалт, амьдрах чадвар*